

ХОТЫН СТАНДАРТЫГ БАТЛУУЛАХ, ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь нийслэлийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хотын стандартыг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх, түүнд хамаарах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Хотын стандартыг батлуулж, хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль болон хүчин төгөлдөр үйлчилж буй холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

ХОЁР. ХОТЫН СТАНДАРТЫГ БОЛОВСРУУЛЖ, БАТЛУУЛАХ

2.1. Хотын стандартын төслийг боловсруулж, батлуулах ажил дараах үе шаттай байна:

- 2.1.1. Хотын стандартын төслийг санаачлах;
- 2.1.2. Хотын стандартын төсөл боловсруулах;
- 2.1.3. Хотын стандартын төслийг хэлэлцүүлж, хянуулах;
- 2.1.4. Хотын стандартыг батлах;

2.2. Хотын стандартын төслийг санаачлах

2.2.1. Хотын стандартыг шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг хотын стандартчиллын үйл ажиллагаанд оролцогч аливаа этгээд гаргах эрхтэй.

2.2.2. Хотын стандартын төсөл боловсруулах талаарх саналыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хагас жил бүр хүлээн авч энэ журмын 2.4.1-д заасан зөвлөлийн хурлаар хэлэлцэн хотын стандартын төсөл боловсруулах төлөвлөгөөнд тусгах эсэх талаар шийдвэрлэнэ.

2.2.3. Энэ журмын 2.2.1-д заасан этгээд нь хотын стандартыг шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах нөхцөл, шаардлагыг шинжлэх ухааны үндэслэл бүхий үнэн бодит судалгааны үр дүнгээр тодорхойлсон байна.

2.3. Хотын стандартын төслийг дараах шаардлагад нийцүүлэн боловсруулна:

2.3.1. Нийслэлийн хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох хууль, тогтоомж, норм, дүрэм, үндэсний стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн байх;

2.3.2. Хотын стандартын төсөл боловсруулах зааврын дагуу боловсруулах;

2.3.3. Нийгэм, эдийн засгийн хөгжил, инноваци, шинжлэх ухаан, технологийн судалгаанд тулгуурласан байх;

2.3.4.Холбогдох мэргэжлийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, 30-аас доошгүй хоногийн хугацаанд санал авсан байх.

2.4.Хотын стандартын төслийг хэлэлцүүлж, хянуулах.

2.4.1.Хотын стандартын төслийг энэхүү журмын 6.2-д заасан Хотын стандартын Зөвлөлийн /цаашид “Зөвлөл” гэх/ хурлаар хэлэлцүүлнэ.

2.4.2.Зөвлөл нь хотын стандартын төслийг хянан хэлэлцэж, энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангасан эсэх талаар дүгнэлт, зөвлөмж гаргана.

2.4.3.Энэхүү журмын 2.4.2-т заасны дагуу холбогдох шаардлагыг хангасан гэж үзвэл Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэх тухай зөвлөмжийг дүгнэлтэд тусгана.

2.4.4.Зөвлөлөөс стандартын төслийг сайжруулах талаар дүгнэлт, зөвлөмж өгсөн бол зөвлөмжийн дагуу хотын стандартын төсөлд өөрчлөлт оруулж, зөвлөлөөр дахин хянуулна.

2.5.Зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хотын стандарт, түүний нэмэлт, өөрчлөлтийн төслийг Нийслэлийн Засаг даргын зүгээс Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, хэлэлцүүлнэ.

2.6.Хотын стандартыг боловсруулахад мэргэжлийн нарийвчилсан судалгаа, шинжилгээ, шинжлэх ухааны туршилт хийх шаардлагатай бол тухайн мэргэжлийн чиглэлээр өндөр мэдлэг, туршлагатай зөвлөх үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж болно.

ГУРАВ. ХОТЫН СТАНДАРТЫГ МЭДЭЭЛЭХ, СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ

3.1.Хотын стандартын асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллага хотын стандартын мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, иргэд, олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулна.

3.2.Хотын стандартыг иргэд, аж ахуй нэгж, байгууллагад сурталчлан таниулах арга хэмжээг тухайн асуудал хариуцсан нийслэлийн нутгийн захиргааны байгууллага гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган зохион байгуулна.

3.3.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчид өөрийн ажиллаж буй салбар, чиглэлд хамаарах хотын стандартын талаар зохих мэдлэг, арга зүйг эзэмшсэн байх ба иргэн, аж ахуйн нэгжүүдийг мэдээлэл, арга зүйгээр хангах үүргийг хүлээнэ.

3.4. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд нь хотын стандарт, түүний хэрэгжилтийн талаарх мэдээ, мэдээллийн төрөл бүрийн контент бүтээх, иргэд, олон нийтэд түгээх талаар хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж болно.

ДӨРӨВ.ХОТЫН СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

4.1.Хотын стандартын асуудал хариуцсан нийслэлийн нутгийн захиргааны байгууллага нь хотын стандартыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дараах арга хэмжээг авч ажиллана:

4.1.1.Батлагдсан хотын стандартыг холбогдох нутгийн захиргааны байгууллага, албан хаагчдад танилцуулах, арга зүйгээр хангах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

4.1.2.Хотын стандартад заасан хэм хэмжээг мөрдөх, ерөнхий болон тусгай шаардлагыг хангуулах талаар аж ахуй нэгж, байгууллага, иргэдэд зориулсан танхимын болон зайн

сургалтыг салбар чиглэл бүрээр баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу жил бүр зохион байгуулах;

4.1.3.Нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжих бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ, тохижилт, засвар, үйлчилгээний ажилд холбогдох хотын стандартыг мөрдөх талаар арга зүйн заавар, зөвлөмжийг ажил эхлүүлэх, гүйцэтгэх, ашиглалтад хүлээн авах үе шатанд ажил гүйцэтгэгч болон захиалагч байгууллагууд, тэдгээрийн инженер, техникийн ажилтан, албан хаагчдад хүргүүлэх.

4.2.Хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээг тухайн салбар, чиглэлийг хариуцсан нутгийн захиргааны байгууллагууд гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган дараах үе шат бүрээр төлөвлөн хэрэгжүүлнэ.

4.2.1.Ажил, үйлчилгээг төлөвлөх, зураг төсөл зохиох, төсөв, зардлын тооцоо гаргахад холбогдох хотын стандартын шаардлага, хэм хэмжээнд нийцүүлэн тусгах;

4.2.2. Бараа, ажил, үйлчилгээнд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг боловсруулах;

4.2.3.Ажил, үйлчилгээг гүйцэтгэх, бараа, бүтээгдэхүүнийг нийлүүлэх явцад хотын стандартын хэрэгжилтэд хяналт тавих;

4.2.4.Бүтээн байгуулалт, засвар, тохижилтын ажлын чанарыг дүгнэж, ашиглалтад хүлээн авах;

4.2.5.Ашиглалт, засвар үйлчилгээ гүйцэтгэх.

4.3.Төрийн хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагууд нь өөрийн хариуцсан салбар, чиглэлийн хүрээнд хотын стандартын хэрэгжилтэд хяналт тавина.

4.4 Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээний үр дүнд хяналт үнэлгээ, мониторинг хийж жил бүр тайлагнана.

ТАВ. ХОТЫН СТАНДАРТАД ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

5.1.Зөвлөлөөс хотын стандартад 2 жил тутамд үзлэг, шинжилгээ хийж, шинэчлэн сайжруулах шаардлагатай эсэх талаар нэгдсэн дүгнэлт гаргана.

5.2.Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хотын стандартад нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл хүчингүй болгох тухай тогтоолын төслийг боловсруулах ажлыг холбогдох нутгийн захиргааны байгууллага хариуцна.

ЗУРГАА.ХОТЫН СТАНДАРТЫГ БАТЛУУЛАХ, МӨРДҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДЫН ЧИГ ҮҮРЭГ

6.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.1.1.Хотын стандартыг боловсруулах, батлуулах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө хариуцан тайлагнах;

6.1.2.Хотын стандартын төслийг хянан хэлэлцэх мэргэжлийн чиг үүрэг бүхий, орон тооны бус “Хотын стандартын зөвлөл”-ийг салбар, мэргэжлийн чиглэлээр байгуулах;

6.1.3.Зөвлөлийн нийтлэг дүрмийг батлах;

6.1.4.Зөвлөлийн ажлыг үнэлж, урамшуулал олгох;

6.2.Хотын стандартын зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.2.1. Хотын стандартын төслийг холбогдох заавар, тавигдах шаардлагад нийцүүлэх талаар төсөл боловсруулагч байгууллага, аж ахуйн нэгжид зөвлөмж өгөх;

6.2.2. Хотын стандартын төслийг хянан хэлэлцэж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулахаар өргөн барих эсэх талаар дүгнэлт, зөвлөмж гаргах;

6.2.3. Хотын стандартын төсөл боловсруулах тухай нутгийн захиргааны болон харьяа байгууллагууд, аж ахуйн нэгж, иргэдийн саналыг судлах, хэлэлцэх;

6.2.4. Хотын стандартын төслийг хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, үндэсний стандарт, техникийн зохицуулалттай нийцүүлэх;

6.2.5. Хотын стандартын зөвлөлийг байгуулахдаа сонирхогч талуудын оролцоог тэгш хангаж, тухайн салбар чиглэлээр мэргэшсэн, судалгааны арга зүйг эзэмшсэн гишүүдээс бүрдүүлэх бөгөөд холбогдох нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулна.

6.2.6. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн баталсан Хотын стандартын зөвлөлийн нийтлэг дүрмийг хэрэгжүүлэх.

6.3. Хотын стандартын асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллага нь Хотын стандартын Зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.3.1. “Нийслэл хотын стандартчиллын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө”-ний төслийг боловсруулах;

6.3.2. Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

6.3.3. Хотын стандартын талаар иргэн, аж ахуйн нэгжид зориулсан сургалт, зөвлөн туслах, арга зүйгээр хангах, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах;

6.3.4. Хотын стандартыг бүртгэх, мэдээллийн санг эрхлэх, албан ёсны эхийг хадгалах, олон нийтэд нээлттэй мэдээлэх;

6.3.5. Хотын стандартыг боловсруулахтай холбогдуулан гадаад, дотоодын эрдэм шинжилгээний болон мэргэжлийн байгууллага, зөвлөхүүдтэй хамтран ажиллах;

6.3.6. “Хотын стандартын төсөл боловсруулах заавар”-ыг боловсруулах;

6.4. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага хотын стандартын талаар дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.4.1. Хариуцсан чиг үүргийн хүрээнд хотын стандартын төслийг боловсруулах, санал өгөх,

6.4.2. Батлагдсан хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх талаар энэхүү журмын 4.2-д заасан ажлыг жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах;

6.4.3. Хотын стандартын хэрэгжилтийг үнэлэхэд хамтран ажиллах;

6.4.4. Хотын стандартын талаар албан хаагчдын мэдлэг, ойлголтыг төлөвшүүлж, сургалтад хамруулах.

ДОЛОО. ХЯНАЛТ ХАРИУЦЛАГА

7.1 Энэхүү журмын дагуу нийслэлийн нутгийн захиргааны болон харьяа байгууллагуудын хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг тэдгээрийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтэд тооцож үнэлнэ.

7.2 Энэхүү журмыг зөрчсөн, чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байгууллага, албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---ooOoo---